

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аудит хийх үндэслэл: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудитор 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн.

Аудитын нэр:

Хууль сахиулах байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулдаг боловч үр дүнг тооцдоггүй, үнэлгээ хийдэггүйгээс төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ.

**Баруун-Урт сум
2017 он**

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор **М.Нарантуяа**

Аудитын менежер **Г.Даваа**

Ахлах аудитор: **Н.Болдбаатар**

Аудитор: **А.Мөнхцэцэг
Б.Мөнхбамбар**

2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Уг тайланг ААГ-ын Веб сайт-аас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал багийн утас 70512127, Газрын дарга, тэргүүлэх аудитор 70518396 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар Баруун-Урт сум 7-р баг төрийн захиргааны байр өрөөний дугаар 226 тоот

Сүхбаатар аймаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3-5
Товчилсон үгийн тайлбар	6
1.1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлон, дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллажээ.	7
1.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гэмт хэргийн шалтгаан нөхцөлтэй уялдаагүй байна	7-8
1.3 Аймгийн ГХСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд захиргааны хяналт хийх арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.	8-9
1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд “Эрхэт цайз” хамгаалалтын алба, болон аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулж ажилласан байна.	9-10
1.5 Аймгийн Цагдаагийн газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт хийгдэж байгаа боловч гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурахгүй байна.	10-11
2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.	12
2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус байгууллагад ямар үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлэх, бие дааж хийх ажлыг тодорхой тусгаж байх шаардлагатай байна.	12
2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй байна.	12-13
3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу ГХУС үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хөрөнгийг бодитой төлөвлөхгүй байна.	13-14
3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт холбогдох хуулиудад нийцэхгүй байна.	14
3.3 ГХУС үйл ажиллагаанд зарцуулсан төсвийн 49 хувь буюу 28612.4 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулжээ.	14-15
3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.	15
Дүгнэлт	15
Зөвлөмж	15
Холбогдох байгууллагын санал	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Үүнд:

- I. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
- II. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх.
- III. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.

3. Аудитын хамрах хүрээ

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, аймгийн ИТХ болон бусад холбогдох төрийн байгууллагуудын 2015-2017 оны үйл ажиллагаа хамрагдав

4. Үндсэн мэдээлэл

УИХ-аас 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” баталсан ба түүнд 2012 оны 01 дүгээр сарын 19, 2013 оны 07 дугаар сарын 05, 2015 оны 12 дугаар сарын 04, 2016 оны 12 дугаар сарын 22, 2017 оны 5 дугаар сарын 18-нд буюу 5 удаагийн өөрчлөлт оруулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэдэг нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль сахиулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд оролцсон өргөн цар хүрээтэй ажил байхаар хуульчлагдсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Улсын прокурорын газар, бүх шатны ИТХ зэрэг байгууллагууд голлох байр суурьтай оролцож байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараахь үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлэхээр заасан байна.

- Гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох,
- Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх,

- Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалт зохион байгуулах

Аймгийн ИТХ-ын дэргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2017 оны 01 дүгээр сарын 18 өдрийн 05 тоот тогтоолоор шинэчлэн байгуулагджээ. Тус зөвлөлийн анхдугаар хурлаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 онд зохион байгуулах үйл ажиллагаа”-ны төлөвлөгөөг баталсан байна.

Аймгийн ИТХ нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олгох төсвийн хөрөнгө, санхүүжилтийн хэмжээг хянан баталдаг.

2016 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд нийт 319 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 57 хүн нас барж, 170 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх онтой харьцуулахад хоёр нэгжээр өсчээ.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 674.5 сая төгрөгийн хохирол учирсны 78.6%-ийг нөхөн төлүүлсэн. Гэмт хэрэг үйлдэж, сэжиглэгдсэн 323 хүний 32.2% нь согтуугаар, 10.2% нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 84.0%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.6 пунктээр буурсан байна.

5. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам, Гүйцэтгэлийн аудитын журмын дагуу аудитын арга зүйг мөрдөж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

6. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр
- Цагдаагийн албаны тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Иргэний хууль
- Эрүүгийн хууль

- Прокурорын байгууллагын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийн төлөвлөгөө

1

Дэд зорилт-1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу

БҮЛЭГ 1

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодорхойлон, дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллажээ.

1.1.1 Цагдаагийн газрын даргын 2015 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн А/04 тоот тушаалаар аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судлах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор судалгаа, дүн шинжилгээний багийг томилон ажлуулсан байна. Судалгааны дүн шинжилгээний баг нь сар бүр хуралдан тухайн сард үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчилд дүгнэлт хийж улирлын байдлаар нэгтгэн цагдаагийн байгууллагын даргыг мэдээлэлээр ханган ажиллажээ. Судалгааны баг нь аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг өмчлөх эрхийн гэмт хэрэг, мал хулгайлах гэмт хэрэг, хувийн өмч хулгайлах, танхайн гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг бүрээр бүлэглэж дүгнэсэн байна. Уг хэргийн үйлдэгдсэн шалтгаан нөхцөл байдлыг үйлдсэн цаг, ашигласан багаж зэвсэг, баг нутаг дэвсгэр, боловсролын түвшин, насны ангилал, хэрэг хийсэн газар зэргээр авч үзжээ. Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоосон, дүн шинжилгээ хийсэн судалгааг Аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ-д хагас бүтэн жилээр хүргүүлжээ. Харин ГХУСАЗСЗ ирсэн дүгнэлтэд дүн шинжилгээ хийх, зөрчил дутагдалтай нь холбогдуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлаа төлөвлөх, уялдаа холбоог хангах зэрэг ажлууд хангалтгүй хийгдсэн байна.

1.1.2 Аймгийн прокурорын газраас аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан, эрүүгийн нөхцөл байдлыг тогтоож, дүн шинжилгээ хийж, зөрчлийг бууруулах талаар анхаарах асуудлыг АИТХ-д хүргүүлэн ажиллажээ.

1.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гэмт хэргийн шалтгаан нөхцөлтэй уялдаагүй байна

1.2.1 Аймгийн хэмжээнд 2016 онд нийт 319 хэрэг бүртгэгдэж гэмт хэргийн улмаас 57 хүн нас барж, 170 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 2 нэгжээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 674.5 сая төгрөгийн хохирол учирсны 78.6 хувийг нөхөн төлүүлсэн. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 0.6 хувиар өсжээ. Нийт дүндээ өссөн боловч хүний амь нас, эрүүл мэнд, тээврийн хэрэгсэл, хүүхэд гэр бүл, нийгмийн аюулгүй байдал, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгүүд 8.6-43.8 хувиар буурсан үзүүлттэй байна.

1.2.2 Аймгийн ГХУСАЗС зөвлөл 2015-2017 оны байдлаар үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр 8-13 арга хэмжээ, ГХУС чиглэлээр 16-19 арга хэмжээг төлөвлөжээ. Харин төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг авч үзэхэд гүйцэтгэл хангалтгүй байна. Гэмт хэргийн шинж чанар, шалтгаан нөхцөлтэй нь уялдуулан төлөвлөгөөг боловсруулаагүй, төлөвлөсөн ажлынхаа биелэлтийг гаргадаггүй, хяналт шинжилгээ хийдэггүй, үр дүнг тооцоогүй зэрэг зохион байгуулалтын дутагдал оршиж байна.

1.2.3 Аймгийн цагдаагийн газар нь 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 хөтөлбөрт 11 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллажээ. Гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн тасаг албад аж ахуйн нэгж байгууллагатай хамтран 96 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцон ажилласан байна.

1.2.4 Цагдаагийн Ерөнхий газар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталжээ. Уг хөтөлбөрийн хүрээнд аймгийн Цагдаагийн газар 7 чиглэлээр 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу 141 сургалт зохион байгуулж 31616 хүн, 9 уралдаан тэмцээнд 886 хүн хамрагдаж, 83 удаа 14450 хүнд яриа таниулга хийж, 54 удаа телевизийн сурталчилгаа явуулж, 16100 ш зурагт хуудас санамж сэрэмжлүүлэгийг тараан үйл ажиллагааг хэрэгжүүлэн биелэлтийг тооцсон байна. ГХУС үйл ажиллагааны төлөвлөгөөг тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, биелэлтийг тооцох, дүн шинжилгээ хийх боломжтой боловсруулах шаардлагатай байна. Мөн тухайн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр арга хэмжээнүүдтэй ГХУС үйл ажиллагааны чиг үүрэг давхардсан, ялгаж салгах боломжгүй хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

1.2.5 Цагдаагийн байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 чиглэлийн хүрээнд 20 арга хэмжээг тусгасан байна. Эхний хагас жилд согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хүүхдийн цахим тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 13 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, сургалт зохион байгуулсан байна. Мөн Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Иргэдэд үзүүлэх эрх зүйн үйлчилгээг сайжруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлцгээе” сэдэвт 45 хоногийн аян гэх мэтчилэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1.3 Аймгийн ГХСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд захиргааны хяналт хийх арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

1.3.1 Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар хорих ял нь тэнссэн 38, хугацааны өмнө суллагдсан 11, ял хойшлогдсон 3, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 нийт 54 хүн захиргааны хяналтанд байна. Хорих газраас хугацаанаасаа өмнө суллагдсан иргэнийг тодорхойлолт мэдэгдлийг үндэслэн бүртгэл судалгааг хөтлөж, хувийн хэрэг үүсгэн ар гэрт нь заавар зөвлөгөө өгөн хүлээлгэн өгч хэсгийн байцаагч, төлөөлөгч нарт хариуцуулан хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ. Цагдаагийн газрын удирдлага болон ОНХА байцаагч нар сар бүр хяналтыг тавьж, захиргааны хяналтын хувийн хэрэг материалыг прокурорт сар бүр хянуулах ажлыг зохион

байгуулж байна. Цагдаагийн газрын захиргааны хяналтанд байгаа хүмүүст тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Нийтийн хэв журмыг хамгаалах тасаг, Эрүүгийн цагдаагийн тасагтай хамтран “Хяналт”, мөн Аймгийн Прокурорын газартай хамтран “Захиргааны хяналтыг сайжруулья” хэсэгчилсэн арга хэмжээ, “Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд тавих захиргааны хяналтыг сайжруулах” 45 хоногийн аян зохион байгуулжээ.

1.3.2 Аймгийн прокурорын газар нь хорих ял нь тэнсэгдсэн болон ял хойшлогдсон, хугацааны өмнө тэнсэн суллагдсан иргэний хувийн хэргийг хянаж, гарсан зөрчлийг арилгуулах мэдэгдэл бичиж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. Мөн Цагдаагийн газрын НХЖХТ-ийн дарга, ОНХА-ны ахлах байцаагч нарын нэгдсэн зөвлөгөөнийг хийж гарч байгаа зөрчил дутагдал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцсэн байна.

1.3.3 Цагдаагийн газрын хэсгийн байцаагч нарын хяналтанд байгаа ялтнуудын дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, хяналтанд байх хугацаандаа засрал хүмүүжлээ олж байгаа ялтнуудыг шагнаж урамшуулах, ялтан нэг бүртэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсох, шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудыг сурталчилан таниулах бүхий “Зөв хүн” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 06 дугаар сарын 14-нд зохион байгуулсан байна. Уг арга хэмжээнд Баруун-Урт сумын хяналтанд байгаа 27 хүнийг хамруулж, Багийн Засаг дарга нараар ялтан нэг бүрийн засрал, хүмүүжлийн талаарх тодорхойлолтыг гаргуулан авч хувийн хэрэгт хавсаргасан байна.

1.3.4 Хууль хүчний байгууллагууд хорих ял эдлээд суллагдсан болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдэд захиргааны хяналт тогтоох чиг үүргийг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.

1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд “Эрхэт цайз” хамгаалалтын алба, болон аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулж ажилласан байна.

1.4.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд байгууллагыг татан оролцуулах зорилгоор Аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/95 тоот захирамж гарч, 37 байгууллагын ажилтнуудыг машинт эргүүл ажиллуулан 73 зөрчил илрүүлэн хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.

1.4.2 Мөн олон нийтийн цагдаагийн ажилтаныг ажиллуулж эхлэх талаар аймгийн ИТХ-ын 2015 оны 02 сарын 26-ны өдрийн 06 тоот тогтоол гаргуулж 2015 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд 18 олон нийтийн цагдаагийн ажилтан ажилласан.

1.4.3 Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран архины хамааралтай, архинд донтох өвчтэй хүмүүсийг “Архины албадан эмчилгээ”-д хамруулах ажлыг зохион байгуулж 4 иргэнийг эмчилгээнд явуулах материалыг бүрдүүлэн эмчилгээний зардлыг ГХУСАЗСЗ-өөр шийдвэрлүүлсэн.

1.4.4 Аймгийн хэмжээнд 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Баруун-Урт сумын “Хөршийн холбоо”-г баг бүрт байгуулах ажлыг багийн засаг дарга, нийгмийн ажилтануудтай хамтран зохион байгуулж нийт 9 хөршийн холбоог байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг зохион байгуулжээ. Хөршийн холбоог эрчимжүүлэх, эрх зүйн сургалт зохион

байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор хөршийн холбооны гишүүдийн нэгдсэн уулзалтыг зохион байгуулсан байна. Мөн хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 28 малчдын бүлэг холбоо байгуулан сумдын хэсгийн төлөөлөгч нарт бүлэг холбоодын ажлыг сайжруулах, идэвхижүүлэх чиглэлээр Цагдаагийн газрын даргын зөвлөмж гарган үр дүнг нь тооцон ажиллажээ.

1.4.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн гэмт хэрэг”, зөрчлөөс урьдчилан сэргийлье” 2 сарын аяныг зохион явуулсан байна. Аяны хүрээнд төрийн болон төрийн бус 45 байгууллагад ухуулга яриа хийж ажилласан ба орон сууцны орц подваль, усан сан болон иргэдийн олноор цуглардаг газруудад 20 ширхэг самбар байрлуулсан.

1.4.6 Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй тогтмол хамтран ажилласан ба 2015 онд 84 удаагийн мэдээ мэдээлэл, 6 удаагийн телевизийн нэврүүлэг, 28 төрлийн богино хэмжээний кино, санамж, сэрэмжлүүлгийг иргэд олон нийтэд байнгын давтамжтайгаар хүргэж ажилласан байна.

1.4.7 2016 онд Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Зөрчлийн илрүүлэлт” ерөнхий арга хэмжээний хүрээнд “Нэгдсэн шалгалт” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж үр дүнг тооцжээ.

1.4.8 Аймгийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн дийлэнхи хувь нь Баруун-Урт суманд үйлдэгдэж байгаад дүгнэлт хийж үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016, 2017 онд “Эрхэт цайз” хамгаалалтын албатай “Нийтийн эргүүл” арга хэмжээг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгажээ.

1.5 Аймгийн Цагдаагийн газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалт хийгдэж байгаа боловч гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурахгүй байна.

1.5.1 Аймгийн цагдаагийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчилах, сургалт зохион байгуулах чиглэлээр он тус бүрд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ. Үүнд:

- **2015 онд** 125 удаагийн сургалт зохион байгуулж 25150 иргэнийг хамруулсан ба 12450 ширхэг санамж сэрэмжлүүлгийг олшруулан тараажээ. Гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн тасаг албад, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж 96 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан байна.
- **2016 онд** 141 удаагийн сургалт, уулзалт ярилцлага, ухуулга яриаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зохион байгуулж давхардсан тоогоор 31616 иргэн хамрагджээ. Мөн иргэд олон нийт байгууллагуудын дунд 9 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж 178 иргэнийг урамшуулжээ.
- **2017 онд** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 оны 3-р улирлын байдлаар 161 удаагийн сургалт, уулзалт өдөрлөг, хэлэлцүүлэг,

зөвлөгөөнийг зохион байгуулж 28186 гаруй иргэнийг хамруулан 12475 гарын авлага, зурагт хуудас, санамж сэрэмжлүүлгийг тарааж ажилласан байна.

1.5.2 Цагдаагийн газраас гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн тасаг албад, төрийн байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээллийг хүргэх чиглэлээр хуулийн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулсан байна.

1.5.3 Судалгааны багийн 2015-2017 оны дүгнэлтээс харахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын тоо өмнөх оноос буурахгүй жил бүр дахин давтагдаж байна. Иймд дээрх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж байгаа ажлуудыг чанар, үр нөлөөг гэмт хэргийн өсөлт, шалтгаан нөхцөлтэй холбогдуулан сайжруулах шаардлагатай байна.

Дэд зорилт-2 : Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна уу?

2

БҮЛЭГ 2 *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаа үр дүнгүй байна.*

2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн болон сумын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл” нь хариуцан зохион байгуулахаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д заасан. Хууль тогтоомжийн хүрээнд хууль хүчний байгууллагууд холбогдох чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч зарим чиг үүргийг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн байна. Үүнд:

- Гэмт хэргийн байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах

2.1.2 ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг бодиттой төлөвлөх, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хэрэгжсэнээр үр дүн бий болох, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай давхардуулахгүйгээр чиг үүргээ тодорхой болгох зэрэг ажлуудыг хийх шаардлагатай юм.

2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус байгууллагад ямар үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлэх, бие дааж хийх ажлыг тодорхой тусгаж байх шаардлагатай байна.

2.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудтай нийцүүлэн Төрийн захиргааны байгууллага, Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг хооронд нь уялдуулах нь зүйтэй байна. Иймээс аймаг, сумын ИТХ-ын ГХУСАЗСЗ-ын үйл ажиллагаа, хууль сахиулах байгууллагуудын чиг үүргүүдийн уялдаа холбоог хангаж өгөх шаардлага үүсчээ. Жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус байгууллагууд ямар үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлэх, бие дааж хийх ажлыг давхардуулахгүйгээр төлөвлөх, орхигдсон зүйл байгаа эсэхийг нягтлах зэргээр хоорондын уялдаа, холбоог хангасан ажил хийгдээгүй байна. Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр чиг үүргүүд нь тодорхой болж, ГХУС үйл ажиллагааны далайц ихсэж, төсөв хөрөнгийн хувьд шийдвэрлээд байх боломжтой болох юм.

2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

2.3.1 Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар ГХУСАЗСЗ бүрэлдэхүүнийг шинэчлэн баталжээ. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2¹-д заасны дагуу боловсруулж, батлаагүй байна.

2.3.2 Аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ 2015-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан боловч хэрэгжилт хангалтгүй, биелэлтийг тооцоогүй, үр дүнг хэлэлцээгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн. Мөн тухайн онд хийгдэх ажлыг тооцоо судалгааны үндсэн дээр боловсруулж төлөвлөөгүй, үйл ажиллагааны тайлангийн биелэлтийг гаргахдаа өмнөх онд хийгдсэн ажлаа давхардуулан, хуулбарлан тооцсон байна. Мөн сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт материал байхгүй, чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

2.3.3 Сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хууль сахиулах байгууллагаас хяналт шалгалт хийхэд Эрдэнэцагаан сумаас бусад сумд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулсан ч хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын тогтмол гүйцэтгэдэг ажлуудыг төлөвлөгөөндөө тусгасан, төлөвлөгөөнүүд бие биенээ хуулбарласан жишигтэй байна. Сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг арга зүйгээр хангах, тогтмол хяналт шинжилгээ хийх, үр дүнг тооцох ажлууд хангалтгүй хэрэгжсэн нь нөлөөлжээ.

3

БҮЛЭГЗ

Дэд зорилт-3: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

Аймгийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төлөвлөсөн төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулжээ.

¹ Улсын хэмжээний зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу ГХУС үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хөрөнгийг бодитой төлөвлөхгүй байна.

3.1.1 Сумдын ГХУСАЗС зөвлөлийн үйл ажиллагаанд 2015-2017 оны байдлаар 4-6 сум төсөв хөрөнгө төлөвлөөгүй бөгөөд төсөв хөрөнгө зарцуулагдаагүй байна. Харин бусад сумдын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу ГХУС үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хөрөнгийг төлөвлөсөн боловч хуульд заасан хувь хэмжээгээр батлагдаагүй байна.

№	Байгууллагын нэр	2016 он			2017 он		
		Хүү, торгуулийн орлого	Баталвал зохих	Баталсан төсөв	Хүү, торгуулийн орлого	Баталвал зохих	Баталсан төсөв
1	Асгат сум ИТХ	1.4	0.5	-	2.7	1.1	-
2	Баяндэлгэр сум ИТХ	2.3	0.9	1.1	0.6	0.2	2.7
3	Баруун-Урт сум ИТХ	101.8	40.7	10.9	105.0	42.0	11.0
4	Дарьганга сум ИТХ	2.7	1.1	2.8	4.5	1.8	-
5	Мөнххаан сум ИТХ	10.6	4.2	8.0	31.9	12.8	9.8
6	Наран сум ИТХ	3.3	1.3	-	1.5	0.6	-
7	Онгон сум ИТХ	3.7	1.5	1.2	3.2	1.3	2.8
8	Сүхбаатар сум ИТХ	6.0	2.4	-	20.0	8.0	-
9	Уулбаян сум ИТХ	2.4	1.0	0.8	2.2	0.9	0.8
10	Түвшинширээ сум ИТХ	3.2	1.3	-	4.1	1.6	1.3
11	Түмэнцогт сум ИТХ	16.3	6.5	0.8	11.2	4.5	0.5
12	Халзан сум ИТХ	3.1	1.2	0.9	1.3	0.5	3.0
13	Эрдэнэцагаан сум ИТХ	12.3	4.9	4.0	23.6	9.4	-
14	Аймгийн ИТХ		-	24.5		-	15.3
	Дүн	169.2	67.7	55.0	211.7	84.7	47.2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2016 онд 12.7 сая төгрөг, 2017 онд 37.5 сая төгрөг тус тус дутуу баталсан байна.

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт холбогдох хуулиудад нийцэхгүй байна.

3.2.1 Аймаг, сумдын ГХУСАЗС зөвлөлүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсвөө төлөвлөж, батлуулсан байна. Харин аймгийн ИТХ 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санд хууль тогтоомжоор заагдаагүй малын гарал үүслийн гэрчилгээний орлого 18621.6 мянган төгрөгийг төвлөрүүлж ГХУС арга хэмжээнд зарцуулах нэрийдлээр байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1 дэх заалтыг зөрчсөн байна. Мөн уг орлогыг аймгийн ИТХ-ын 2013 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн 05 дугаар тогтоол гарч Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн дансанд төвлөрүүлж байсан бөгөөд уг сан нь 2016 онд хаагдсан байна.

3.3 ГХУС үйл ажиллагаанд зарцуулсан төсвийн 49 хувь буюу 28612.4 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулжээ.

3.2.1 Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд зориулж 2015-2017 онд орон нутгийн төсөвт дараах хөрөнгийг баталсан байна. Үүнд:

- **2015 онд** аймгийн ИТХ-ын төсөвт 16700.0 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр 16696.5 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санд эхний үлдэгдэл мянган төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр 15448.6 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 7962.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 32145.1 мянган төгрөг олгосон боловч 20696.5 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зориулалт бус зарцуулсан.
- ГХУС үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын 2016 оны төсөвт 24497.4 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр 23001.9 мянган төгрөг зарцуулснаас байгууллагын урсгал үйл ажиллагаанд 6532.9 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бус зарцуулсан байна.
- 2017 онд аймгийн ИТХ-ын төсөвт 15286.6 мянган төгрөг баталж, эхний хагас жилийн байдлаар 3391.0 мянган төгрөг зарцуулсан боловч шатахуун, авто машины сэлбэг, үйлчилгээний хөлс зэрэгт 1383.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

3.2.2 Дээрх зориулалт бус зарцуулсан зөрчлийг шинж чанараар нь авч үзвэл байгууллагын хэрэгцээний аж ахуйн материалд 1,3 сая, урсгал засварт 2.8 сая, шатахуунд 6.0 сая, гадаад томилолт, түүнтэй холбогдон гарсан 13.5 сая, цэвэр бохир усанд 0.4 сая, бусад зардалд 4.6 сая төгрөг нийтдээ 2015-2017 оны байдлаар 28.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан. Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 заалтуудыг зөрчиж байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн үр ашиг, хөтөлбөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр албан шаардлага хүргүүлээ.

3.2.3 Батлагдсан төсвийг үр дүнгүй, зориулалт бус зарцуулж байгаа нь ГХУС үйл ажиллагааны үр дүн, чиг үүргийг бууруулж байна. Мөн ГХУС үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд Хууль сахиулах байгууллагуудын төсөв хөрөнгө хүрэлцээ муутай байдаг байна. Иймд ГХУС үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллагууд ажлаа уялдуулах, төсөв хөрөнгийн хувьд орон нутгаас дэмжлэг үзүүлж байх нь зүйтэй байна.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

3.4.1 ГХУС тухай хуулийн 19.5²-д заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт хийгдээгүй байна. Энэ нь төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах, батлагдсан хөтөлбөр арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх нөхцөл үүсч байна.

² Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах “ДҮГНЭЛТ” хийж байна. Үүнд

1. Хууль сахиулах байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь үр дүнгүй, хангалтгүй хэрэгжсэн байна.
3. Аймгийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төлөвлөсөн төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулжээ.

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн дор дурьдсан байгууллага, албан тушаалтанд “ЗӨВЛӨМЖ” хүргүүлжээ. Үүнд

ГХУСАЗСЗ-д

- *Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн журмыг боловсруулж, түүнд тавих хяналтыг сайжруулах,*
- *ГХУС үйл ажиллагааны төлөвлөгөөг судалгаа шинжилгээтэй боловсруулж, тогтмол хяналт шинжилгээ хийж хэрэгжилтийг үнэлж, дүгнэх*
- *Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд эрх зүйн тусалцаа үзүүлж, ажлын үр дүнг дээшлүүлэх*
- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1 дэх заалтын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг бодиттой төлөвлөж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.*

Аймгийн Цагдаагийн газарт

- *ГХУС үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ гэмт хэргийн гаралт, жилээс жилд өссөн байдлыг харгалзан түүнд тохируулан иргэдэд хийх сургалт, сурталчилгаа төлөвлөж, чанар үр дүнг дээшлүүлэх*
- *ГХУС үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлж, хэрэгжилтэд тогтмол хяналт шинжилгээ хийн, үнэлэлт дүгнэлт өгөх*
- *ГХУСАЗСЗ-ийн ГХУС үйл ажиллагааны төлөвлөгөөг өөрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах замаар орон нутгийн төсвөөс дэмжлэг авах асуудлыг шийдвэрлүүлэх*

Холбогдох байгууллагын санал


МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518877

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.НАРАНТУЯА ТАНАА

2017. 10. 23 № 01/276.
танай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

"Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, ГХУСА33-ийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхээр дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журмыг "Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх тухай хууль"-ийн холбогдох заалтын дагуу шинэчлэн боловсруулах.
2. Аймгийн ГХУСА33-ийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хууль сахиулах байгууллагуудаас авсан санал дээр үндэслэн судалгаа, тооцоотой боловсруулж, ГХУСА33-ийн хурлаар хэлэлцэн баталж хэвших.
3. Аймгийн ГХУСА33-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам дүгнэж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт материалыг бүрдүүлдэг болох.
4. Аймаг, сумын ГХУСА33 зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасны дагуу авахын тулд журам боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулах.
5. Нэгэнт батлагдсан ГХУСА33 зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг зориулалтын дагуу зарцуулахын тулд жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан төсвийн нарийвчилсан хуваарь гарган мөрдөн ажиллах.
6. Сумдын ГХУСА33-ийн эрх зүйн туслалцааг тогмол үзүүлж, хамтарч ажиллан, ажлын үр дүнг дээшлүүлэх.
7. ГХУСА хариуцсан ажилтны ажлын хариуцлага, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.

ДАРГА  Б.МӨНХБАТ



0100 551

Саналд өгөх тайлбар : Аймгийн ИТХ-аас тайлангийн төсөлтэй танилцаж, ГХУСА33-ийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахаар саналаа албан тоотоор ирүүлсэн тул тайлбар хийгдээгүй болно.


Тайлбар 1. Аудитын тайлангийн 1.1-т бичигдсэн учир саналын зөрүүгүй гэж үзлээ.

Тайлбар 2. Саналыг Цагдаагийн газарт зөвлөмжөөр өгсөн.

Тайлбар 3. Уг саналыг тайлангийн 2.1.2, 2.2.1, 3.2.3-т тусгагдсан.

Тайлбар 4. Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжилтийг түр хугацаагаар хангах боломжгүй байна.

Тайлбар 5. Саналыг хүлээн авч тайланд холбогдох өөрчлөлтийг хийв.


СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР
213100 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас: 70-51-87-51

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА ТАНАА


2017.10.24 № 19/1645
Тавий _____ -нх № _____ -т

Санал хүргүүлэх тухай

Тус аймгийн Цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:


- Цагдаагийн газраас аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоосон, дүн шинжилгээ хийсэн судалгааг аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ-д хагас бүтэн жилээр хүргүүлдэг. Аймгийн ГХУСАЗСЗ хүргүүлсэн дүгнэлтэд дүн шинжилгээ хийх, гэмт хэргийн шинж чанар, шалтгаан нөхцөлтэй нь холбогдуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлаа төлөвлөх, хяналт шинжилгээ хийж үр дүнг нь тооцдоггүй
- Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 заалт "Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд Цагдаагийн газрын төсөвт ямар нэгэн хөрөнгө байдаггүй тул ГХУС үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллагууд хамтарч ажиллах, төсөв хөрөнгийн хувьд орон нутгаас дэмжлэг үзүүлж байх
- Мөн Олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулах талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаартай тогтоолын хэрэгжилтийг хангах зэрэг саналуудыг холбогдох газарт нь уламжилж өгөх
- Хорих ял эдлээд суллагдсан болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдэд захиргааны хяналт тогтоох чиг үүргийг цагдаагийн байгууллага, хяналт тавихыг Прокурорын байгууллага хэрэгжүүлдэг тул Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төслийн 1.3 заалт "Аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд захиргааны хяналт хийх арга хэмжээг төлөвлөж батлаагүй" гэсэн заалтыг хасч, хорих ял эдлээд суллагдсан болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдэд захиргааны хяналт тогтоох чиг үүргээ хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн гэж оруулах саналтай байна.

Цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн тайланд ирүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  Н.БОЛДБААТАР

АУДИТОР  А.МӨНХЦЭЦЭГ

 Б.МӨНХБАМБАР

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 М.НАРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

 Г.ДАВАА



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/18

Баруун-Урт

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, 11, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Хууль сахиулах байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2018 оны 05 дугаар сарын 15-ний дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа /Т.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2017/tushaal

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны 12 сарын 23-ны өдрийн 418 тоот тушаалын хавсралт

“Хууль сахиулах байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

Дугаар	Акт, албан шаардлагын ангилал, аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1/85	Албан шаардлага ҮАГ-ГАГ/2017/09-ГА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас байгууллагын хэрэгцээний аж ахуйн материалд 1.3 сая, урсгал засварт 2.8 сая, шатахуунд 6.0 сая, гадаад томилолт, түүнтэй холбогдон гарсан 13.5 сая, цэвэр бохир усанд 0.4 сая, бусад зардалд 4.6 сая төгрөг нийтдээ 2015-2017 оны байдлаар 28.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.3-т заасан арга хэмжээнд зарцуулж ажиллах.	28.6

--- оОо ---